

**Э.ЭНХСАЙХАН**

ХСИС-ийн Удирдлагын
сургуулийн 821 дүгээр
дамжааны сонсогч,
ахмад

ХОРИГДОГСДЫН ЭРХИЙГ ХАНГАХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ

1990 оны ардчилсан хувьсгалаас хойших төр нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцад урган гарч ирсэн эрх зүйн шинэтгэлийн асуудал нь зүй ёсных байсан бөгөөд 2002 онд Монгол Улсын Эрүү, Иргэн, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд шинээр мөрдөгдөж эхэлснээр тайлбарлагдаж болно.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Баривчлах, цагдан хорих байр” нь Цагдаагийн байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд шилжин ирж, хорих байрны нөхцөл журам, стандартыг орчин үеийн жишигт хүргэх зорилт тавин ажиллаж ирсэн.

Монгол Улсын Үндсэн хууль, үүнтэй нийцүүлэн нэгдэн орсон, соёрхон баталсан Олон Улсын гэрээ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон төрөлжсөн хуулиуд зэрэг эрх зүйн баримт

бичгүүдэд тусгагдсан хоригдогсдын хуулиар хязгаарлаагүйгээс бусад эрхийг хангаж эдлүүлэх асуудал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагын тэргүүний зорилтуудын нэг юм.

Монгол Улсад сэжигтэн, яллагдагчийг урьдчилан хорих ажиллагаа олон арван жилийн турш Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагыг удирдах газрын чиг үүрэгт хамаарагдаж байсан.

Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны бүтцэд эргэлтийн шинжтэй өөрчлөлт орсон 1990 онд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагыг удирдах газар Монгол улсын Хууль зүйн яамны харьяанд очиход сэжигтэн, яллагдагчийг урьдчилан хорих ажил Цагдаагийн байгууллагын харьяанд шилжин очсон юм. Энэ байдал 12 жил үргэлжилсэний эцэст Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Тогтоол гүйцэтгэх газрын чиг үүрэгт хамаарагдах болов.¹⁸⁵

Хоригдогсодын эрхийг хангах ажиллагаа нь тэдгээрийн хоригдож буй орчин нөхцөл, албан хаагчдын үйл ажиллагаа, хоригдогсдын зан үйл, эрх зүйн хэм хэмжээ дагаж мөрдөж байгаа байдал зэргийн нийлбэр цогцоор хангагдаж байдаг.

¹⁸⁵ А.Лхагва “Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”. УБ., 2008 он

Хоригдсон этгээдтэй холбогдох харилцаа нь “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”, “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”, “Аливаа хэлбэрээр хоригдсон болон саатуулагдсан бүх хүнийг хамгаалах зарчмуудын цогц” зэрэг олон улсын баримт бичгүүдэд тусгагдсан байна.

Хүний эрхийн асуудал дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа энэ цаг үед өөрийн орны хорих байгууллага дахь хүний эрхийн асуудал, хоригдож буй этгээдийн эрхийн байдлын тухай өнөөгийн байдлын талаар тал бүрээс нь нарийвчлан судалж түүний үндсэн дээр хууль эрх зүйн талаас нь шаардлагатай арга хэмжээг шинжлэх ухааны судалгааны үндсэн дээр гаргаж үнэлэлт дүгнэлт өгөх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийг зүй ёсоор шаардагдаж байна.

Монгол Улс дахь хоригдогсдын эрхийн байдал, ерөнхий шинжийг тодорхойлохдоо нэгдүгээрт, асуудлыг хүний эрх, эрх чөлөөний нийтлэг ойлголтод тулгуурлах, хоёрдугаарт, хоригдогсдын эрхийн байдлын талаар НҮБ-аас гаргасан баримт бичигт хэрхэн тусгагдсан, гуравдугаарт, үндэсний хууль

тогтоомжид энэ асуудал яаж заагдсан, дөрөвдүгээрт, хуульч эрдэмтэд хоригдогсдын эрхийн байдлын талаар ямар үзэл бодол дэвшүүлэн тавьдаг, тавдугаарт, НҮБ-ын болон үндэсний хууль тогтоомжийн заалт, түүний практик хэрэгжилт, төрөөс хүний эрхийг хангах ажиллагаатай холбон авч үзэх шаардлагатай юм.

Асуудлыг ингэж үе шаттай, харилцан хамааралтайгаар авч үзэх нь нэг талаар шинжлэх ухааны, нөгөө талаар практик ач холбогдолтой гэж үзэж болно.

«Хүний эрх» гэдэг бол орчин үеийн нэр томъёо хэдий ч, түүний гарал үүсэл нь хүн төрөлхтөн үүссэн лугаа адил өнө эртний ойлголт юм. Монголын ард түмэн төрт ёсны түүхт хоёр мянга гаруй жилийн туршид дэлхийн бусад орны ард түмний нэгэн адил хүний эрх, эрх чөлөөний төлөө тэмцсээр ирсэн түүхтэй.

Энэ үүднээс авч үзвэл хүний эрх, эрх чөлөө нь тэдний оршин байхад зайлшгүй шаардлагатай тулгуур нөхцөл болдог байна. Энэ нь хүн бүрийн нэр хүнд, хүн байхын утга учрыг хүндэтгэхэд үндэслэсэн бөгөөд хүн гэж байгаагаас улбаалсан хүн бүрт байх салшгүй эрх юм. Энэ бол ямар нэг давуу эрх дарх биш, мөн тухайн улс орны төр, удирдагчдын бэлэг ч бус бөгөөд ямар нэг дур зоргын хүчээр салган авч чаддаг зүйл ч биш юм. Харин аливаа этгээдийн гэмт хэрэг үйлдсэний болон ямар нэг хууль зөрчсөний төлөө эрхийн хязгаарлал

байхыг үгүйсгэх аргагүй. Хүний эрх нь урт удаан хугацаанд хууль зүйн үндэслэлгүй явж ирсэн бөгөөд зөвхөн ёс суртахууны зүйлд тооцогдож байжээ. Ингээд хүн төрөлхтөний хөгжлийн явцад хүний эрх нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөж хуулиар хамгаалагдах болсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19-р зүйлийн 2 дахь хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан билээ. Эндээс үзвэл хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах нь төр засгийн сайн санааны үйлс бус, харин Үндсэн хуулиар төр засаг ард түмнээс ногдуулсан үүрэг юм.

Хүний эрхийг хангах төрийн үүрэг нь дан ганц тухайн улс хүний эрх, эрх чөлөөг Үндсэн хууль болон бусад хуульдаа зааж өгөх, түүнчлэн хүний эрхийн асуудлаарх олон улсын гэрээнд элсэн орох явдлаар хязгаарлагддаггүй. Харин тухайн улсад хүний эрх, эрх чөлөө нь үндэсний болон олон улсын эрх зүйгээр хамгаалагдсан эсэх, гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хязгаарлах эрсдэл гарахаас сэрэмжлэх чадавхтай эсэх, зөрчигдсөн тохиолдолд сэргээх шударга шүүхийн тогтолцоо ажиллаж чадаж байгаа эсэхээс

хамааран хүний эрх, эрх чөлөө хангагдах шалгуур болдог.

Төр нь дотооддоо хүний эрхийг хангахдаа өөрийн тогтолцоог сайтар ажиллуулах үүрэг хүлээдэг. Эдгээр тогтолцоог нийтэд нь хүний эрхийг хамгаалах төрийн механизм хэмээн нэрийдэж байна. (Төрийн механизм нь нутгийн захиргааны болон орон нутгийн өөрөө удирдах ёсны болон иргэний нийгмийн байгууллагуудын тогтолцоотой нэгдэн хүний эрхийг хамгаалах үндэсний механизмыг бүрдүүлдэг)

Орчин үеийн нийгмийг эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны зарчимд үндэслэсэн хүний эрхгүйгээр төсөөлөх боломжгүй юм. Хүнээс түүний жам ёсны эрх болох амьд явах, халдашгүй дархан байх, эрүү шүүлтээс ангид байх, шүтэж бишрэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө, сурч боловсрох болон бусад эрхийг хэн ч хасах эрхгүй бөгөөд төр тэдгээрийг хүлээн зөвшөөрч, хангах, хамгаалах үүрэгтэй билээ.

* * *

